



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 6/01

Хатан суудал

**С.Ганхүлэгийг Багийн Засаг даргын  
ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 64 дүгээр зүйлийн 64.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага баян 3 дугаар багийн Засаг дарга Сүхбатын Ганхүлэг нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгогдсон тул 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.С.Ганхүлэгтэй холбогдох санхүүгийн болон эд хөрөнгийн тооцоог бүрэн хийж дуусгахыг Нягтлан бодогч (Г.Тунгалаг), Нярав (П.Норовсамбуу) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642301387



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 6/09

Хатан суудал

**А.Элдэв-Очирыг багийн Засаг даргын  
үүрэг гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 56 дугаар зүйлийн 56.6, 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Амаржаргалын Элдэв-Очирыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс Бага баян 3 дугаар багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр түр томилсугай.

2.С.Ганхүлэгээс А.Элдэв-Очирт ажил хүлээлцэх ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Мөнхсүх (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

А.Гантулга (Хүнс, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн)

П.Норовсамбуу (Нярав)

Д.Тогоохүүхэн (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Б.Адъяасүрэн (Оператор, хүний нөөцийн мэргэжилтэн)

3.А.Элдэв-Очирын үндсэн цалинг мөн өдрөөс 1,250,000 (Нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгөөр тогтоож, холбогдох нэмэгдлийг бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх), Нягтлан бодогч (Г.Тунгалаг) нарт зөвшөөрсүгэй.

4.Ажлыг хууль, дүрэм журмын дагуу хүлээлцэж акт үйлдэхийг Ажлын хэсэг (Г.Мөнхсүх)-т үүрэг болгосугай.

5 Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд сахиж, холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Бага баян 3 дугаар багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (А.Элдэв-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА  О.МӨНХБАТ